



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2016 ОНЫ IV УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


## Төлбөрийн тэнцэл

2016 оны IV улиралд (10-12 сар) урсгал данс 6.7 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 245 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 214 сая ам.долларын ашигтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр өссөн байна. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -24.4 сая ам.доллар байна.

2015 оны IV улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 250 сая ам.доллараар, харин хөрөнгө ба санхүүгийн данс 34 сая ам.доллараар тус тус буурсан байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,296.4 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




## Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,889 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 30,222 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2016 оны IV улирлын байдлаар 26,333 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 7% буюу 1,633 сая ам.доллараар өссөн.

Үүнд багцын хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 4,565 сая ам.доллар, 571 сая ам.доллараар тус тус өсч, харин шууд хөрөнгө оруулалтын богино позиц 3,782 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц




## Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 24,264 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11%-иар буюу 2,434 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын гадаад өр 34%-иар буюу 1247 сая ам.доллараар өсч 4,894 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 9%-иар буюу 169 сая ам.доллараар буурч 1,791 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 19%-иар буюу 393 сая ам.доллараар өсч 2,438 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 131%-иар буюу 4583 сая ам.доллараар өсч 8,084 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 34%-иар буюу 3,619 сая ам.доллараар буурч 7,056 сая ам.долларт тус тус хүрсэн байна.


Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



## Гадаад секторын статистик

Гадаад секторын статистик төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.

Дүрслэл 4. Статистик хамаарал



# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## УРСГАЛ ДАНС

2016 оны IV улиралд урсгал тэнцлийн алдагдал 6.7 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2015 оны мөн үеэс 97%-иар буурчээ.

Өнгөрсөн оны мөн үед алдагдалтай гарч байсан бараа, үйлчилгээний худалдаа энэ улиралд 292 сая ам.долларын ашигтай гарав. Тайлант хугацаанд барааны дансны ашиг 540 сая ам.доллараар, үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 118 сая ам.доллараар тус тус өссөн байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 24%-иар буурч 2,470 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд 607 сая ам.долларт хүрч, сүүлийн 10 улирал дараалан ашигтай гарлаа. Барааны худалдааны тэнцэл сайжрахад тайлант улиралд нефтийн импорт 12%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 18%-иар буурсан, алт болон нүүрсний экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

## Үйлчилгээний худалдаа

Тайлант улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны IV улирлын гүйцэтгэлээс 118 сая ам.доллараар өсч 316 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 93 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ. Бусад үйлчилгээний зардал өсөхөд архитектур, инженер техникийн болон барилгын үйлчилгээний өсөлт голлон нөлөөлжээ.

## Орлого

2016 оны IV улирлын гүйцэтгэлээр орлогын данс 306 сая ам.долларын алдагдалтай гарч 2015 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 69%-иар буюу 125 сая ам.доллараар өссөн. Тайлант хугацааны голлох төлбөрийг дурьдвал:

- Монгол Улсын Засгийн газар бонд, гадаад зээлийн эх үүсвэрт 35 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- ААН-ийн гадаадын хөрөнгө оруулагчдад 45 сая ам.долларын ногдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 53 сая ам.долларын хүү төлсөн,
- ААН-ийн бусад гадаад зээлийн эх үүсвэрт 135 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 32 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Төр, хувийн хэвшил хамтдаа бондын эх үүсвэрт 44 сая долларын хүүгийн төлбөрийг төлсөн байна.


## Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 14.7%-иар буурсан. Үүний зэрэгцээ гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 22.6%-иар өссөн. Ингэснээр ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 21 сая ам.доллар болж буурсан байна.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	IV улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
<b>I. Урсгал тэнцэл</b>	<b>-256</b>	<b>-7</b>	<b>250</b>	<b>97%</b>
<b>A. Бараа, үйлчилгээний худалдаа</b>	<b>-130</b>	<b>292</b>	<b>421</b>	<b>-325%</b>
а. Бараа	68	607	540	797%
б. Үйлчилгээ	-197	-316	-118	-60%
<b>B. Цэвэр орлого</b>	<b>-182</b>	<b>-306</b>	<b>-125</b>	<b>-69%</b>
<b>V. Урсгал шилжүүлэг</b>	<b>55</b>	<b>8</b>	<b>-47</b>	<b>-86%</b>

Дүрслэл 5. Барааны худалдаа



Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	17,383	36% ▲	43%	1,631	6% ▼	-28%
Америк	7,560	15% ▲	51%	5,788	21% ▼	-31%
Хятад	1,880	4% ▼	-29%	2,937	11% ▼	-56%
Гонг Конг	700	1% ▼	-46%	339	1% ▼	-89%
Англи	3,885	8% ▲	30%	358	1% ▼	-65%
ОХУ	734	2% ▼	-38%	1,942	7% ▲	28%
Сингапур	513	1% ▼	-28%	247	1% ▼	-66%
Швейцарь	169	0% ▼	-91%	3	0% ▼	-100%
Герман	1,056	2% ▼	-18%	596	2% ▼	-18%
Япон	975	2% ▲	41%	532	2% ▼	-42%
Бусад	13,929	29% ▲	57%	13,411	48% ▲	54%
<b>НИЙТ</b>	<b>48,784</b>	<b>100%</b>		<b>27,784</b>	<b>100%</b>	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)

	IV улирал			Өөрчлөлт	
	2014	2015	2016	Мөнгөн дүн	Хувиар
<b>Ажилчдын гуйвуулга (цэвэр)</b>	<b>6.8</b>	<b>21.3</b>	<b>21.0</b>	<b>-0.3</b>	<b>-1.4%</b>
<b>Гаднаас орж ирсэн</b>	<b>49.4</b>	<b>57.2</b>	<b>48.8</b>	<b>-8.4</b>	<b>-14.7%</b>
<b>Гадагш шилжүүлсэн</b>	<b>-42.6</b>	<b>-35.9</b>	<b>-27.8</b>	<b>8.10</b>	<b>-22.6%</b>

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 245 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 34 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Ийнхүү буурсан нь багцын болон шууд хөрөнгө оруулалтын дансны эх үүсвэрээс голлон шалтгаалж байна.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2016 оны IV улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 206 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 39 сая ам.доллараар өссөн байна. Үүнд ААН-ийн орлогын дахин хөрөнгө оруулалт буюу ашигт ажиллагаа өнгөрсөн оны мөн үеэс 42 сая ам.доллараар өсч –50 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл,

- Гонг-Конгоос орж ирсэн хөрөнгө оруулалт 2015 оны IV улиралд 195 сая ам.доллар байсан бол 2016 оны IV улиралд 238 сая ам.долларт,
- Сингапур улсын хөрөнгө оруулалт 4 сая ам.доллараас 2016 оны IV улиралд 18 сая ам.долларт хүрч тус тус өссөн, харин
- Герман улсын хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 39 сая ам.доллараар буурч –38 сая ам.долларт хүрч буурчээ.

Эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2016 оны IV улиралд манай улсад орсон нийт хөрөнгө оруулалтын өсөлтийн 56%-ыг буюу 118 сая ам.долларыг уул уурхайн салбарт, 14% буюу 29 сая ам.долларыг санхүү, даатгалын салбарт, 13% буюу 27 сая ам.долларыг худалдааны салбарт оруулсан хөрөнгө оруулалтууд тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал,

- уул уурхайн салбар 123.3 сая ам.доллар,
- санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 22.6 сая ам.доллар,
- барилга 7.2 сая ам.доллараар тус тус өсч,
- зочид буудал, байр, сууц 94.2 сая ам.доллар,
- үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 14.8 сая ам.доллар, бөөний болон жижиглэнгийн худалдаа 9.3 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 23 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 29 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

### Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 45 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тэнцэл 87 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	IV улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
<b>II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл</b>	<b>279</b>	<b>245</b>	<b>-34</b>	<b>12%</b>
<b>A. Хөрөнгийн данс</b>	<b>30</b>	<b>19</b>	<b>-11</b>	<b>-36%</b>
<b>B. Санхүүгийн данс</b>	<b>249</b>	<b>226</b>	<b>-23</b>	<b>-9%</b>
a. Шууд хөрөнгө оруулалт	168	206	39	-23%
Гадагш хийсэн	-7	-5	1	-21%
Монгол Улсад орсон	175	212	37	-21%
б. Багцын хөрөнгө оруулалт	-52	-23	29	56%
в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2	-2	-4	199%
г. Бусад хөрөнгө оруулалт	132	45	-87	-66%
Үүнээс: Худалдааны зээл	41	-107	-149	359%
Бэлэн мөнгө харилцах	-220	231	450	-205%

Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	IV улирал		2016.IV/15.IV	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	-5.0	-2%	3.3	▲
2	Америк	35.8	17%	7.9	▲
3	Англи	-3.0	-1%	4.4	▲
4	Бельги	-2.0	-1%	-3.6	▼
5	БНХАУ	8.1	4%	-6.9	▼
6	Герман	-38.2	-18%	-39.1	▼
7	Голланд	-39.5	-19%	9.8	▲
8	Гонг-Конг	238.1	112%	42.8	▲
9	Канад	-9.5	-5%	3.7	▲
10	Люксембург	5.8	3%	1.0	▲
11	Малайз	-2.3	-1%	-2.4	▼
12	ОХУ	-3.3	-2%	-0.6	▼
13	Сингапур	18.1	9%	14.5	▲
14	Солонгос (өмнөд)	-5.7	-3%	0.8	▲
15	Швейцарь	3.4	2%	-0.8	▼
16	Япон	17.9	8%	5.8	▲
17	Бусад	-6.8	-3%	-3.4	▼
	<b>Нийт</b>	<b>211.8</b>	<b>100%</b>	<b>37.2</b>	<b>▲</b>

Хүснэгт 6. ГШХО, ЭЗ-ийн салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	IV улирал		2016.IV/15.IV	
		2015	2016	Өөрчлөлт	
1	Барилга	6.2	13.4	7.2	▲
2	Боловсрол	0.7	0.8	0.2	▲
3	Боловсруулах үйлдвэрлэл	3.6	1.2	-2.4	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	35.8	26.6	-9.3	▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	94.3	0.1	-94.2	▼
6	Мэдээлэл, холбоо	0.5	10.2	9.7	▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4.7	1.6	-3.2	▼
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	6.0	28.6	22.6	▲
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.2	4.8	2.6	▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6.7	4.8	-1.9	▼
11	Уул уурхай, олборлолт	-5.7	117.6	123.3	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3.3	2.1	-1.2	▼
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9.1	-5.7	-14.8	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.7	1.2	0.5	▲
15	Бусад	6.5	4.5	-2.0	▼
	<b>Нийт</b>	<b>174.6</b>	<b>211.8</b>	<b>37.2</b>	<b>▲</b>

## Алдаа ба орхигдуулга

2016 оны IV улиралд алдаа ба орхигдуулга үзүүлэлт –24.4 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд дотогш чиглэсэн хөрөнгийн урсгал илүү бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

## II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2016 оны IV улирлын эцэст -26,333.4 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 26.3 тэрбум ам.доллараар их байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат бус этгээдэд оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,888.9 сая ам.доллар байна. Үүний 48%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 33%-ийг гадаад валютын албан нөөц, 10%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 9%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 30,222.3 сая ам.долларт хүрчээ. Үүний 43%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 45%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 46%-ийг буюу 5,924.0 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 54% буюу 7,056.4 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх улирлаас 0.6%-иар буюу 169.6 сая ам.доллараар өссөн байна.

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 3.9%-иар буюу 146.4 сая ам.доллараар, гадаад пассив 1.1%-иар буюу 316.0 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 232.8 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 203.5 сая ам.доллараар тус тус өссөнөөр, харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 60.8 сая ам.доллараар, гадаад валютын албан нөөц 204.0 сая ам.доллараар тус тус буурснаар тус тус тайлбарлагдаж байна.


Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 34.5 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 54.2 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр -356.9 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 170 сая ам.доллараар өөрчлөгдсөнөөр тайлбарлагдахаар байна.

Гадаад активын дүн өсч байгаа нь гадаад валютын улсын нөөцийн өсөлтөөс шалтгаалсан бол гадаад пассивын өсөлт нь бусад хөрөнгө оруулалтын тодруулбал ААН-үүдийн хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл болон Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлтөөр голлон шалтгаалжээ.


Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	IV улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
<b>II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл</b>	<b>279</b>	<b>245</b>	<b>-34</b>	<b>12%</b>
<i>A. Хөрөнгийн данс</i>	<i>30</i>	<i>19</i>	<i>-11</i>	<i>-36%</i>
<i>B. Санхүүгийн данс</i>	<i>249</i>	<i>226</i>	<i>-23</i>	<i>-9%</i>
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>	168	206	39	-23%
<i>Гадагш хийсэн</i>	-7	-5	1	-21%
<i>Монгол Улсад орсон</i>	175	212	37	-21%
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	-52	-23	29	56%
<i>в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</i>	2	-2	-4	199%
<i>г. Бусад хөрөнгө оруулалт</i>	132	45	-87	-66%
Үүнээс: Худалдааны зээл	41	-107	-149	359%
Бэлэн мөнгө харилцах	-220	231	450	-205%

Дүрслэл 7. Гадаад актив



Дүрслэл 8. Гадаад пассив



## Багцын хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад актив 2016 оны IV улирлын эцэст 337.4 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 44%-иар, гадаад пассивын үлдэгдэл 3,640.5 сая ам.долларт хүрч 23%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**Актив:** эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл, Гонг конг 62%, Австрали 12%, АНУ 8%, Сингапур 6%, Канад 4%, БНХАУ 3%, Их Британи 2%, Швейцарь 1%, Солонгос 1%-ийг эзэлж байна.

**Пассив:** эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал, Сингапур 21%, Гонг конг 14%, Япон 5%, АНУ 2%, БНХАУ 2%, бусад улс 20%, үлдсэн 42% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас эзэлж байна.

## Компаниудын хувьцааны үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэ 2016 оны IV улиралд өмнөх жилийн мөн үеийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 84%-иар өсчээ. Тодруулбал,

**Өссөн:** Винсвэй Кокинг кол компаний хувьцааны үнэ 600%, Петро матад 160%, Монголиа Майнинг корпораци 100%, Монголиан энерги корпораци 53%, Тюркуойс Хилл ресурс 27%, Пропеси кол корпораци 25%-иар өссөн.

**Буурсан:** Писс мап холдинг компаний хувьцааны үнэ 70%, Саусови ресурс 28%, Харанга ресурс 25%, Сентера Голд 5%-иар буурсан үзүүлэлттэй байна.

## Засгийн газрын бондын үнэ


2016 оны IV улирлаас дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ өсч, үүнтэй уялдан ЗГ-ын бондуудын үнэ бага зэрэг өсөлттэй байсан. 2017 оны 2 дугаар сарын 23-ны байдлаарх бондуудын үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал Засгийн газрын 5 жилийн хугацаатай бондын үнэ 16.8%, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэ 35.5%, Дим сам бондын үнэ 16.6%-иар тус тус өссөн байна.

2016 оны III болон IV улиралд олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагууд /S&P, Мүүдиз, Фич/ манай улсын зээлжих зэрэглэлийг бууруулсантай холбоотойгоор ЗГ-ын бондуудын өгөөж өсч 5 жилийн хугацаатай бондын өгөөж 11.0%, 10 жилийн хугацаатай бондын өгөөж 9.2%-д хүрч өсч байсан.

Харин манай улс өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах тухай эхний тохиролцоог ОУВС-н ажлын хэсэгтэй хийсэнтэй холбоотойгоор бондуудын өгөөж буурч 2017 оны 2 дугаар сарын 23-ны байдлаар 5 жилийн хугацаатай бондын өгөөж 4.3%, 10 жилийн хугацаатай бондын өгөөж 6.4%-д хүрч буурсан байна.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын позицын статистикт ЗГ-ын бондуудыг зах зээлийн үнэлгээгээр тооцдог бөгөөд 2016 оны IV улирлын эцсийн байдлаар 5 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 483.4 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 858.3 сая ам.доллар, Дим Сам бондын үнэлгээ 152.6 сая ам.доллар, Мазаалай бондын үнэлгээ 527 сая ам.доллар байна.

Дүрслэл 9. Багцын ХО-ын позиц, 2016.IV\* улирал, сая ам.доллар




\* Урьдчилсан гүйцэтгэлээр

Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ


№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					12/31/2015	12/31/2016	
1	Turquoise Hill Resources	TRQ.US	US	USD	2.54	3.23	27% ▲
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.18	0.36	100% ▲
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	6.59	6.29	-5% ▼
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	2.40	1.73	-28% ▼
5	Wingway Cocking Coal	1733.HK	HK	HKD	0.15	1.05	600% ▲
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.18	0.28	53% ▲
7	Petro Matad	MATD.L	LN	GBP	3.13	8.13	160% ▲
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.04	0.05	25% ▲
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.00	0.00	-25% ▼
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.38	0.11	-70% ▼

Дүрслэл 10. ЗГ-н бондын үнэ, Түүхий эдийн үнийн индекс



\* 2016 оны IV сарын 6 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.

Дүрслэл 11. МУ-н ЗГ-н бондуудын өгөөжийн муруй



\* 2016 оны IV сарын 6 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.  
\* CRB index - 22 нэр төрлийн бараа, түүхий эдийн үнээс бүрдсэн индекс.

## IV. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны IV улирлын байдлаар 24,264 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2,435 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 1,246 сая ам.доллараар нэмэгдэж 4,894 сая ам.долларт хүрсэн, харин Монголбанкны гадаад өр 169 сая ам.доллараар буурч 1,791 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 1,357 сая ам.доллараар өсч 17,579 сая ам.долларт хүрээд байна.

### Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2016 оны IV улирлын эцэст 2,438 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19%-иар буюу 393 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 61%-ийг урт хугацаат зээл, 19%-ийг бонд өрийн бичиг, 12%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 7%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат зээлийн үлдэгдэл харгалзан 2,031 сая ам.доллар, 408 сая ам.долларт тус тус хүрчээ.

### Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2016 оны IV улирлын эцэст 15,141 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 964 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 47% буюу 7,056 сая ам.долларын эх үүсвэр нь ААН-үүдийн гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Энэхүү зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 530 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	Өөрчлөлт		* %2
			дүн	хувь	
Нийт гадаад өр	21,829	24,264	2,435	11%	100%
I. Засгийн газар	3,648	4,894	1,246	34%	20%
II. Төв банк	1,960	1,791	-169	-9%	7%
III. Банк	2,045	2,438	393	19%	10%
Богино хугацаат	331	408	76	23%	2%
Урт хугацаат	1,714	2,030	317	18%	8%
IV. Бусад сектор	3,501	8,084	4,583	131%	33%
Богино хугацаат	409	404	-5	-1%	2%
Урт хугацаат	3,093	7,681	4,588	148%	32%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	10,676	7,056	-3,619	-34%	29%

\* Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр

Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



### Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

**ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)**

Үзүүлэлт	IV улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2014	2015	2016	Дүн	2015/14	Дүн	2016/15
<b>I. Урсгал Тэнцэл</b>	<b>-81</b>	<b>-256</b>	<b>-7</b>	<b>-175</b>	<b>215%</b>	<b>250</b>	<b>97%</b>
<b>A. Бараа ба үйлчилгээний худалдаа</b>	<b>179</b>	<b>-130</b>	<b>292</b>	<b>-308</b>	<b>-173%</b>	<b>421</b>	<b>325%</b>
<b>1. Бараа</b>	<b>458</b>	<b>68</b>	<b>607</b>	<b>-390</b>	<b>-85%</b>	<b>540</b>	<b>797%</b>
1.1 Ерөнхий эд бараа	273	-66	251	-339	-124%	317	480%
Экспорт Ф.О.Б. (Кредит)	1,472	894	1,179	-579	-39%	285	32%
Үүнээс: Зэсийн баяжмал	0	0	367	0	0%	367	-
Импорт Ф.О.Б. (Дебит)	-1,200	-960	-928	240	-20%	32	3%
Үүнээс: Нефтийн Хүнсний	0	0	-175	0	0%	-175	-
Хүнсний	0	0	-126	0	0%	-126	-
1.2 Мөнгөжөөгүй алт	191	134	359	-57	-30%	225	167%
Кредит	191	134	359	-57	-30%	225	167%
Дебит	0	0	0	0	-	0	-
1.3 Бусад	-6	-1	-3	5	-88%	-2	-297%
Кредит	1	3	1	2	176%	-2	-57%
Дебит	-7	-4	-4	3	-47%	0	-12%
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-279</b>	<b>-197</b>	<b>-316</b>	<b>82</b>	<b>-29%</b>	<b>-118</b>	<b>-60%</b>
2.1 Тээвэр	-48	-25	-28	23	-48%	-3	-11%
Кредит	51	57	60	6	12%	3	5%
Дебит	-99	-82	-88	17	-17%	-6	-7%
2.2 Аялал	-81	-46	-70	34	-43%	-24	-51%
Кредит	29	59	50	30	102%	-9	-15%
Дебит	-110	-105	-120	5	-4%	-15	-14%
2.3 Бусад үйлчилгээ	-150	-126	-218	24	-16%	-92	-73%
Кредит	39	54	63	15	37%	9	17%
Дебит	-190	-180	-281	10	-5%	-101	-56%
<b>B. Орлого</b>	<b>-279</b>	<b>-182</b>	<b>-306</b>	<b>97</b>	<b>-35%</b>	<b>-125</b>	<b>-69%</b>
1. Ажиллагсдын цалин хөлс	-45	-9	-9	36	-81%	-1	-9%
Кредит	13	14	16	1	9%	2	12%
Дебит	-58	-23	-25	35	-61%	-2	-11%
2. Хөрөнгө оруулалтын орлого	-234	-173	-297	61	-26%	-124	-72%
Кредит	1	1	2	0	59%	1	47%
Дебит	-234	-174	-298	60	-26%	-124	-71%
<b>C. Урсгал шилжүүлэг (цэвэр)</b>	<b>19</b>	<b>55</b>	<b>8</b>	<b>36</b>	<b>191%</b>	<b>-47</b>	<b>-86%</b>
Кредит	67	96	68	29	44%	-28	-29%
Дебит	-48	-41	-60	7	-14%	-19	-47%
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	7	21	21	15	35x	0	-1%
Кредит	49	57	49	8	16%	-8	-15%
Дебит	-43	-36	-28	7	-16%	8	23%
<b>II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл</b>	<b>346</b>	<b>279</b>	<b>245</b>	<b>-67</b>	<b>-19%</b>	<b>-34</b>	<b>-12%</b>
<b>A. Хөрөнгийн данс</b>	<b>21</b>	<b>30</b>	<b>19</b>	<b>9</b>	<b>41%</b>	<b>-11</b>	<b>-36%</b>
Кредит	21	30	19	9	42%	-11	-36%
Дебит	0	0	0	0	-	0	6%
<b>B. Санхүүгийн данс</b>	<b>325</b>	<b>249</b>	<b>226</b>	<b>-76</b>	<b>-23%</b>	<b>-23</b>	<b>-9%</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>-245</b>	<b>168</b>	<b>206</b>	<b>413</b>	<b>-168%</b>	<b>39</b>	<b>23%</b>
1.1 Гадагш хийсэн	-88	-7	-5	82	-92%	1	21%
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-88	-6	-3	82	-93%	3	50%
1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	0	0	0	0	-	0	-
1.1.3 Бусад хөрөнгө	0	-1	-2	-1	6x	-2	-269%
1.2 Монголд орсон	-157	175	212	331	-211%	37	21%
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	80	65	56	-15	-19%	-10	-15%
1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	-51	-92	-50	-41	81%	42	46%
1.2.3 Бусад хөрөнгө	-186	202	206	388	-209%	5	2%
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>-114</b>	<b>-52</b>	<b>-23</b>	<b>62</b>	<b>91x</b>	<b>29</b>	<b>56%</b>
2.1 Актив	-23	0	0	22	-98%	1	180%
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-23	0	1	23	-100%	1	5236%
2.1.2 Өрийн бичиг	0	0	0	0	0%	0	-15%
2.1.2.1 Бонд, үнэт цаас	0	0	0	0	0%	0	-17%
2.1.2.2 Мөнгөний захын	0	0	0	0	-	0	-
2.2 Пассив	-91	-52	-23	39	276x	29	55%
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	-2	2	-1	5	-220%	-3	-131%
2.2.2 Өрийн бичиг	-89	-54	-23	35	146x	32	59%
2.2.2.1 Бонд, үнэт цаас	-89	-54	-23	35	146x	32	59%
2.2.2.2 Мөнгөний захын	0	0	0	0	-	0	-
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>-2</b>	<b>2</b>	<b>-2866%</b>	<b>-4</b>	<b>-199%</b>
3.1 Актив	-6	5	14	11	-192%	8	151%
3.2 Пассив	6	-3	-16	-9	7x	-12	-351%
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>684</b>	<b>132</b>	<b>45</b>	<b>-552</b>	<b>-81%</b>	<b>-87</b>	<b>-66%</b>
4.1 Актив	308	-5	-37	-313	-102%	-32	-658%
4.1.1 Худалдааны зээл	27	22	-67	-5	-19%	-89	-405%
4.1.2 Зээл	1	0	0	-1	-86%	0	-251%
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	280	-27	30	-307	-110%	57	213%
4.1.4 Бусад актив	0	0	0	0	-	0	-
4.2 Пассив	376	137	81	-239	-64%	-56	-41%
4.2.1 Худалдааны зээл	27	20	-41	-7	-27%	-60	-309%
4.2.2 Зээл	203	290	-66	87	43%	-356	-123%
4.2.2.1 Төв банк	0	0	0	0	-	0	-
4.2.2.2 Засгийн газар	96	162	125	66	-	-37	-23%
4.2.2.3 Банк	101	162	-118	61	60%	-280	-173%
4.2.2.4 Бусад сектор	6	-34	-73	-40	-692%	-40	-116%
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	158	-193	200	-351	-222%	393	204%
4.2.4 Бусад пассив	-12	20	-12	32	-267%	-32	-160%
0	0	0	0	-	-	-	-
<b>III. Алдаа болон орхигдуулга</b>	<b>7</b>	<b>-118</b>	<b>-24</b>	<b>-126</b>	<b>-1689%</b>	<b>94</b>	<b>79%</b>
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	272	-96	214	-368	-135%	310	324%
<b>IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*</b>	<b>-272</b>	<b>96</b>	<b>-214</b>	<b>368</b>	<b>-135%</b>	<b>-310</b>	<b>-324%</b>
<b>1. Актив</b>	<b>-266</b>	<b>96</b>	<b>-214</b>	<b>362</b>	<b>-136%</b>	<b>-310</b>	<b>-324%</b>
1.1 Мөнгөжсөн алт	0	0	0	0	-	0	-
1.2 Зээлжих тусгай эрх	0	0	0	0	-97%	0	-35%
<b>1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
1.4 Бэлэн валют ба харилцах	-267	96	-214	362	-136%	-310	-324%
1.5 Бусад нөөц актив	0	0	0	0	-	0	-
<b>2. Пассив</b>	<b>-6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>6</b>	<b>-100%</b>	<b>0</b>	<b>-</b>
2.1 ОУВС-ийн зээл	-6	0	0	6	-100%	0	-
2.2 Онцгой санхүүжилт	0	0	0	0	-	0	-

\* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

Эх сурвалж: Монголбанк

**ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)**

Үзүүлэлт	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016	12/31/2016
<b>Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)</b>	<b>-20,440</b>	<b>-23,689</b>	<b>-24,066</b>	<b>-24,284</b>	<b>-24,488</b>	<b>-24,701</b>	<b>-25,103</b>	<b>-25,919</b>	<b>-26,164</b>	<b>-26,333</b>
<b>I. Гадаад актив</b>	<b>4,005</b>	<b>3,437</b>	<b>2,999</b>	<b>3,660</b>	<b>3,240</b>	<b>3,230</b>	<b>3,561</b>	<b>3,591</b>	<b>3,742</b>	<b>3,889</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>	<b>258</b>	<b>355</b>	<b>367</b>	<b>375</b>	<b>376</b>	<b>382</b>	<b>378</b>	<b>381</b>	<b>384</b>	<b>393</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба алгийн дахин хөрөнгө оруулалт	252	348	360	366	364	369	365	368	371	381
1.1.1 Салбар компаниас авах	252	348	360	366	364	369	365	368	371	381
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	6	7	7	10	12	13	13	13	13	13
1.2.1 Салбар компаниас авах	6	7	7	10	12	13	13	13	13	13
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>387</b>	<b>280</b>	<b>288</b>	<b>315</b>	<b>251</b>	<b>235</b>	<b>239</b>	<b>254</b>	<b>326</b>	<b>337</b>
2.1 Хөрөнгийн хувьцаа	379	205	213	246	218	202	206	220	292	303
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.3 Банкууд	0	0	0	3	3	3	3	3	3	3
2.1.4 Бусад салбар	379	205	213	243	215	199	203	218	289	301
2.2 Өрийн бичиг	9	75	76	70	33	33	33	33	34	34
2.2.1 Бонд, үнэт цаас	0	52	52	52	15	15	15	15	16	16
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	0	0	0	0	1	1	1	1	1	1
2.2.1.4 Бусад салбар	0	52	52	52	14	15	15	15	15	15
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	8	24	24	18	18	18	18	18	18	18
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	8	24	24	18	18	18	18	18	18	18
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>13</b>	<b>8</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>16</b>	<b>3</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	9	1	2	13	8	13	9	16	3
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>1,112</b>	<b>1,144</b>	<b>1,019</b>	<b>1,281</b>	<b>1,188</b>	<b>1,283</b>	<b>1,665</b>	<b>1,651</b>	<b>1,924</b>	<b>1,859</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>540</b>	<b>566</b>	<b>535</b>	<b>611</b>	<b>516</b>	<b>607</b>	<b>666</b>	<b>676</b>	<b>669</b>	<b>748</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	540	566	535	611	516	607	666	676	669	748
Урт хугацааны	5	4	4	5	4	4	4	5	5	6
Богино хугацааны	534	562	531	606	512	603	662	671	664	742
<b>4.2 Зээл</b>	<b>5</b>	<b>51</b>	<b>51</b>	<b>52</b>	<b>53</b>	<b>52</b>	<b>64</b>	<b>64</b>	<b>53</b>	<b>54</b>
4.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	2	49	50	50	51	51	63	63	51	52
Урт хугацааны	0	45	45	46	46	47	47	48	48	49
Богино хугацааны	2	4	4	4	4	4	16	16	3	3
4.2.4 Бусад салбар	3	2	2	2	2	1	1	1	1	2
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	3	2	2	2	2	1	1	1	1	2
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>567</b>	<b>527</b>	<b>433</b>	<b>618</b>	<b>619</b>	<b>623</b>	<b>935</b>	<b>911</b>	<b>1,202</b>	<b>1,057</b>
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	494	315	299	430	474	441	613	587	1,005	761
4.3.4 Бусад салбар	73	212	134	188	146	182	323	325	197	296
<b>4.4 Бусад актив</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
4.4.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>5. Нөөц актив</b>	<b>2,248</b>	<b>1,650</b>	<b>1,324</b>	<b>1,686</b>	<b>1,413</b>	<b>1,323</b>	<b>1,265</b>	<b>1,297</b>	<b>1,092</b>	<b>1,296</b>



Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016	12/31/2016
<b>II. Гадаад пассив</b>	<b>20,599</b>	<b>24,445</b>	<b>27,127</b>	<b>27,066</b>	<b>27,944</b>	<b>27,728</b>	<b>27,931</b>	<b>28,664</b>	<b>29,510</b>	<b>29,906</b>	<b>30,222</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	<b>13,458</b>	<b>15,729</b>	<b>16,693</b>	<b>16,517</b>	<b>16,575</b>	<b>16,512</b>	<b>16,680</b>	<b>16,822</b>	<b>12,727</b>	<b>12,738</b>	<b>12,980</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969	5,921	5,924
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969	5,921	5,924
1.2 Бусад хөрөнгө	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758	6,817	7,056
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758	6,817	7,056
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>2,689</b>	<b>2,470</b>	<b>2,913</b>	<b>2,906</b>	<b>3,590</b>	<b>3,043</b>	<b>2,961</b>	<b>2,975</b>	<b>3,634</b>	<b>3,690</b>	<b>3,641</b>
<b>2.1 Хөрөнгийн хувьцаа</b>	<b>113</b>	<b>35</b>	<b>94</b>	<b>87</b>	<b>94</b>	<b>82</b>	<b>84</b>	<b>76</b>	<b>79</b>	<b>72</b>	<b>72</b>
2.1.1 Банкууд	0	0	11	11	11	11	11	11	11	11	11
2.1.2 Бусад салбар	113	35	83	76	83	71	73	65	68	61	61
<b>2.2 Өрийн бичиг</b>	<b>2,576</b>	<b>2,435</b>	<b>2,819</b>	<b>2,819</b>	<b>3,496</b>	<b>2,961</b>	<b>2,877</b>	<b>2,899</b>	<b>3,555</b>	<b>3,617</b>	<b>3,569</b>
2.2.1 Бонд, үнэт цаас	2,576	2,435	2,819	2,819	3,494	2,959	2,875	2,897	3,553	3,615	3,566
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	2,080	2,080	1,500	1,500	1,685	1,460	1,418	1,395	1,964	2,063	2,047
2.2.1.3 Банкууд	495	351	473	472	959	668	649	643	692	642	630
2.2.1.4 Бусад салбар	1	4	847	847	851	831	808	859	897	910	889
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0	0	0	0	2	2	2	2	2	2	3
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	0	0	0	0	2	2	2	2	2	2	3
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>12</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>16</b>	<b>13</b>	<b>18</b>	<b>13</b>	<b>21</b>	<b>5</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	12	4	6	16	13	18	13	21	5
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>4,452</b>	<b>6,246</b>	<b>7,508</b>	<b>7,639</b>	<b>7,773</b>	<b>8,157</b>	<b>8,277</b>	<b>8,850</b>	<b>13,137</b>	<b>13,458</b>	<b>13,596</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>252</b>	<b>511</b>	<b>594</b>	<b>438</b>	<b>538</b>	<b>455</b>	<b>470</b>	<b>476</b>	<b>539</b>	<b>523</b>	<b>530</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	252	511	594	438	538	455	470	476	539	523	530
Урт хугацааны	31	339	291	212	358	282	302	307	368	370	359
Богино хугацааны	221	173	303	226	180	173	167	168	171	153	171
<b>4.2 Зээл</b>	<b>3,621</b>	<b>4,427</b>	<b>5,165</b>	<b>5,187</b>	<b>5,199</b>	<b>5,308</b>	<b>5,626</b>	<b>6,021</b>	<b>10,606</b>	<b>10,882</b>	<b>10,994</b>
4.2.1 Төв банк	78	75	71	68	69	68	68	68	68	68	65
ОУВС-гийн зээл	78	75	71	68	69	68	68	68	68	68	65
Бусад урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742	2,696	2,805
Урт хугацааны	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742	2,696	2,805
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	337	629	904	902	890	936	1,106	1,080	1,173	1,426	1,461
Урт хугацааны	279	429	589	611	613	713	775	727	785	1,027	1,053
Богино хугацааны	58	200	315	290	277	223	331	353	389	399	408
4.2.4 Бусад салбар	1,023	1,538	2,081	2,162	2,183	2,222	2,221	2,232	6,622	6,692	6,663
Урт хугацааны	735	1,305	1,822	1,901	1,912	1,976	1,982	1,994	6,333	6,397	6,432
Богино хугацааны	288	233	259	261	271	246	239	237	290	296	230
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>142</b>	<b>160</b>	<b>1,589</b>	<b>1,877</b>	<b>1,921</b>	<b>2,183</b>	<b>1,954</b>	<b>2,157</b>	<b>1,848</b>	<b>1,933</b>	<b>1,965</b>
4.3.1 Төв банк	0	0	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928	1,654	1,649	1,725
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	142	160	140	104	151	140	182	229	193	284	240
4.3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>4.4 Бусад пассив</b>	<b>436</b>	<b>1,147</b>	<b>160</b>	<b>138</b>	<b>114</b>	<b>212</b>	<b>228</b>	<b>196</b>	<b>144</b>	<b>119</b>	<b>107</b>
4.4.1 Төв банк	336	990	48	36	12	100	120	88	36	12	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	336	990	48	36	12	100	120	88	36	12	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	100	157	112	102	102	112	108	108	108	107	107
Урт хугацааны	100	157	112	102	102	112	108	108	108	107	107
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)**

<b>Үзүүлэлт</b>	<b>12/31/2015</b>	<b>3/31/2016</b>	<b>6/30/2016</b>	<b>9/30/2016</b>	<b>12/30/2016</b>
<b>Засгийн газар</b>	3,647,908.3	4,035,818.1	4,705,847.6	4,758,967.8	4,894,472.3
<b>Төвбанк</b>	1,959,642.7	2,084,477.7	1,758,003.5	1,729,173.2	1,790,753.4
<b>Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)</b>	2,045,033.4	2,060,644.7	2,167,219.1	2,351,436.9	2,438,107.2
<b>Бусад салбарууд</b>	3,501,335.7	3,568,258.1	8,060,410.4	8,127,859.8	8,084,399.2
<b>Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын</b>	10,675,547.2	10,849,575.8	6,757,621.3	6,817,319.3	7,056,380.2
<b>Нийт гадаад өр</b>	<b>21,829,467.2</b>	<b>22,598,774.4</b>	<b>23,449,101.8</b>	<b>23,784,756.9</b>	<b>24,264,112.3</b>